



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Матад сумын Соёлын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **ДОА-2021/44/СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга	
Чойбалсан хот	бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул	
2021 он	Утас: 7058-4203	Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
	Аудитын менежер:	И.Сэмжидмаа
	Утас: 7058-4207	Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
	Аудитор:	Э.Нандинчимэг
	Утас: 7000-3775	Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ЗТХС	Зам тээвэр хөгжлийн сайд
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам



Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3.Аудитын тайлан.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	10
3.4. Материаллаг байдал	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	11
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.9. Аудитын илрүүлэлт.....	12
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	12
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	13
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	14



1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.25 № 301

танай _____-ны № _____-т

Г ДОРНОД АЙМГИЙН МАТАД СУМЫН
СОЁЛЫН ТӨВИЙН ЭРХЛЭГЧИЙН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.АМАРСАНАА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Матад сумын соёлын төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Матад сумын соёлын төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дорнод аймгийн Матад сумын соёлын төвийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө дүгнэгдээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011020284



Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	37,554,455.00	35,850,062.42
35	БАРАА МАТЕРИАЛ	37,554,455.00	35,850,062.42
351	Түүхий эд материал	8,572,839.00	8,154,013.00
35110	Тусгай зориулалттай материал	8,572,839.00	8,154,013.00
354	Хангамжийн материал	28,981,616.00	27,696,049.42
35420	Аж ахуйн материал	12,939,467.00	10,673,867.00
35470	Бусад хангамжийн материал	16,042,149.00	17,022,182.42
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	354,576,589.84	404,492,031.42
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	354,576,589.84	404,492,031.42
392	Биет хөрөнгө	350,564,589.84	400,480,031.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	30,747,814.20	30,747,814.20
39202	Хуримтлагдсан элэгдэл	(27,046,438.20)	(27,786,713.40)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	32,593,651.00	45,216,733.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(12,301,220.76)	(18,636,932.13)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,722,164.40	72,007,275.51
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,828,131.08)	(10,147,646.16)
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,972,500.00	10,972,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,295,749.72)	(1,892,999.80)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	300,000,000.00	300,000,000.00
393	Биет бус хөрөнгө	4,012,000.00	4,012,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	4,012,000.00	4,012,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	392,131,044.84	440,342,093.84
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	387,214.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	387,214.00
413	Өглөг	-	387,214.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	387,214.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	392,131,044.84	439,954,879.84
51	Засгийн газрын хувь оролцоо	392,131,044.84	439,954,879.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	352,928,413.40	352,928,413.40
51101	Өмч: - төрийн	352,928,413.40	352,928,413.40
512	Хуримтлагдсан үр дүн	34,030,277.12	81,854,112.12
51210	Өмнөх үеийн үр дүн	34,030,277.12	34,030,277.12
51220	Тайлант үеийн үр дүн	-	47,823,835.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,172,354.32	5,172,354.32
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV+V	392,131,044.84	440,342,093.84



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	-	75,910,814.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	75,910,814.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	75,454,814.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	75,454,814.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	456,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	300,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	156,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	85,995,315.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	85,995,315.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	83,630,452.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	49,924,901.00
210101	Үндсэн цалин	-	37,932,351.00
210102	Нэмэгдэл	-	11,992,550.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	8,108,616.53
210201	Тэтгэврийн даатгал	-	5,662,012.27
210202	Тэтгэмжийн даатгал	-	508,401.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	592,521.15
210204	Ажилгүйдлийн даатгал	-	121,880.29
210205	Эрүүл мэндийн даатгал	-	1,223,801.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	3,311,807.00
210301	Гэрэл, пахилгаан	-	162,131.00
210302	Түлш, халаалт	-	2,800,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	349,676.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	5,806,276.00
210401	Бичиг хэрэг	-	499,050.00
210402	Тээвэр, шатахуун	-	151,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	275,000.00
210404	Ном, хэвлэл	-	568,826.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	25,000.00
210406	Бага үнэтэй, гургэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	4,287,100.00
2105	Нормативт зардал	-	2,197,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	2,197,100.00
2107	Томилголт, зочны зардал	-	230,000.00
210702	Дотоод албан томилголт	-	230,000.00
2108	Буслаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	759,000.00
210801	Буслаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	579,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	13,292,751.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	300,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	12,992,751.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	2,364,863.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	350,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	350,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	2,014,863.47
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,014,863.47
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-	(10,084,501.73)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-	(10,084,501.73)



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	-	75,910,814.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	75,910,814.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	75,454,814.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	75,454,814.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	456,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	300,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	156,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	-	75,910,814.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	75,910,814.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	73,545,950.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	49,537,687.00
210101	Үндсэн цалин	-	37,545,137.00
210102	Нэмэгдэл	-	11,992,550.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	8,108,616.53
210201	Тэтгэврийн даатгал	-	5,662,012.27
210202	Тэтгэмжийн даатгал	-	508,401.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	592,521.15
210204	Ажилгүйдлийн даатгал	-	121,880.29
210205	Эрүүл мэндийн даатгал	-	1,223,801.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	3,311,807.00
210301	Гэрэл, цахилгаан	-	162,131.00
210302	Түлш, халаалт	-	2,800,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	349,676.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	3,163,350.00
210401	Бичиг хэрэг	-	499,050.00
210402	Тээвэр, шатахуун	-	151,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	275,000.00
210404	Ном, хэвлэл	-	150,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	25,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	2,063,000.00
2105	Нормативт зардал	-	500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	7,479,490.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	7,479,490.00
2107	Томилолт, зочны зардал	-	230,000.00
210702	Дотоод албан томилолт	-	230,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	759,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	579,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	456,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	456,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	2,364,863.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	350,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	350,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	2,014,863.47
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,014,863.47
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	352,928,413.40	5,172,354.32	34,030,277.12	0.00	392,131,044.84
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	352,928,413.40	5,172,354.32	34,030,277.12	0.00	392,131,044.84
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
Тайлант үеийн үр дүн					0.00
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	352,928,413.40	5,172,354.32	34,030,277.12	0.00	392,131,044.84
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	352,928,413.40	5,172,354.32	34,030,277.12	0.00	392,131,044.84
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	352,928,413.40	5,172,354.32	34,030,277.12	0.00	392,131,044.84
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	47,823,835.00	0.00	47,823,835.00
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	352,928,413.40	5,172,354.32	81,854,112.12	0.00	439,954,879.84

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	64,389,000.00	54,308,444.53	76,523,500.00	73,439,950.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	64,389,000.00	54,308,444.53	76,523,500.00	73,439,950.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	64,089,000.00	54,258,444.53	76,023,500.00	73,089,950.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	44,070,900.00	40,779,637.53	50,961,100.00	49,537,687.00
210101	Үндсэн цалин	38,012,300.00	36,767,025.53	39,497,900.00	37,545,137.00
210102	Нэмэгдэл			11,463,200.00	11,992,550.00
210105	Гэрээт ажлын хөлс	6,058,600.00	4,012,612.00	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,508,800.00	5,508,900.00	8,432,200.00	8,108,616.53
210201	Тэтгэврийн даатгал	3,746,000.00	3,746,100.00	5,933,900.00	5,662,012.27
210202	Тэтгэмжийн даатгал	352,600.00	352,600.00	499,600.00	508,401.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	440,700.00	440,700.00	624,600.00	592,521.15
210204	Ажилгүйдлийн даатгал	88,100.00	88,100.00	124,900.00	121,880.29
210205	Эрүүд мэндийн даатгал	881,400.00	881,400.00	1,249,200.00	1,223,801.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,300,000.00	4,058,207.00	3,365,200.00	3,311,807.00
210301	Гэрэл, цахилгаан	1,700,000.00	408,207.00	215,200.00	162,131.00
210302	Тулш, халаалт	5,600,000.00	2,800,000.00	2,800,000.00	2,800,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	850,000.00	350,000.00	349,676.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,769,300.00	1,689,200.00	3,975,000.00	3,163,350.00
210401	Бичиг хэрэг	250,000.00	249,900.00	500,000.00	499,050.00
210402	Тээвэр, шатахуун	509,000.00	429,000.00	425,000.00	151,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	205,300.00	205,300.00	300,000.00	275,000.00
210404	Ном, хэвлэл	75,000.00	75,000.00	150,000.00	150,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал			100,000.00	25,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	730,000.00	730,000.00	2,500,000.00	2,063,000.00
2105	Нормативт зардал	2,500,000.00	1,000,000.00	500,000.00	500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,500,000.00	1,000,000.00	500,000.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00	7,900,000.00	7,479,490.00
210601	Багаж, техник, хэрэгсэл			7,600,000.00	7,479,490.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00	300,000.00	-
2107	Томилголт, зочны зардал	330,000.00	330,000.00	500,000.00	230,000.00
210702	Дотоод албан томилголт	330,000.00	330,000.00	500,000.00	230,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,110,000.00	392,500.00	390,000.00	759,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	930,000.00	232,500.00	200,000.00	579,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	160,000.00	180,000.00	180,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж			10,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,000.00	50,000.00	500,000.00	350,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	50,000.00	500,000.00	350,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	50,000.00	500,000.00	350,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	64,389,000.00	54,308,444.53	76,523,500.00	75,454,814.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	64,389,000.00	54,308,444.53	76,523,500.00	75,454,814.00
132001	Орон нутгийн төсвөөс	64,389,000.00	54,308,444.53	76,523,500.00	75,454,814.00



2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	456,000.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	456,000.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	456,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	456,000.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	456,000.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	456,000.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	456,000.00	
	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт			
131104	тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	300,000.00	
	Төсвийн байгууллагын үндсэн үйл			
131105	ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	156,000.00	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(I)			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	



3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Матад сумын Соёлын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Д.Амарсанаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ы хооронд Улаанбаатар хот дахь Хаан консалтинг Аудит ХХК-ийн аудитор Э.Нандинчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Матад сумын Соёлын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Матад сумын Соёлын төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Төрөөс баримталж буй соёлын бодлогыг иргэдэд хүргэхээр ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Матад сумын Соёлын төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Матад сумын Соёлын төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.



Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 85,995.3 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 1,720.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Матад сумын Соёлын төв 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 48,211.1 мянган төгрөгөөр буюу 12.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	37,554.4	35,850.1	-1,704.3
Үндсэн хөрөнгө	354,576.5	404,492.0	49,915.5
Нийт хөрөнгө	392,131.0	440,342.1	48,211.1
Өр төлбөр	-	387.2	387.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	352,928.4	352,928.4	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	392,131.0	440,342.1	48,211.1

Бараа материалын дансны үлдэгдэл 35,850.1 мянган төгрөг болж 1,704.3 мянган төгрөгөөр буурсан нь 2,28.1 мянган төгрөгийн аж ахуйн материал дээрх хөрөнгийг данснаас хасаж, 2,939.8 мянган төгрөгийн хөгжмийн зэмсгийн хэрэгсэл хандиваар хүлээн авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 440,342.1 мянган төгрөг болж 48,211.1 мянган төгрөгөөр өссөн нь Орон нутгийн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтаар 49,454.0 мянган төгрөгийн үзэгчдийн сандал, 5,514.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг хандиваар хүлээн авснаас нэмэгдсэн байна.

Матад сумын Соёлын төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос мянган төгрөгөөр буюу 57.4 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос мянган төгрөгөөр буюу 41.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, хангамжийн материалын зардал бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Энэ нь цалин нэмэгдсэн, бараа материал зарлагадсан зэргээс шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 76,523.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 76,523.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 76,523.5 мянган төгрөгөөр баталсан байна.



Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 76,523.5 мянган төгрөгийг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 75,484.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 75,484.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 73,439.9 мянган төгрөгийг зарцуулж 2,014.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 73,925.9 мянган төгрөг буюу 97.3 хувьтай байна. Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 57,646.3 мянган төгрөг буюу 78.0 хувийг эзэлж байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Өөрийн үйл ажиллагаанаас 456.0 мянган төгрөгийн орлого орсон байна. Урлагийн дээл, соёлын арга хэмжээнд зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 144 мэдээллээс хугацаандаа оруулсан 143 мэдээлэл, хугацаа хоцроосон 1 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар худалдан авалтын и-баримттай холбоотой зөвлөмжийг хэрэгжүүлсэн, шатахууны зарцуулалттай холбоотой 1 албан шаардлагыг биелүүлсэн.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 444,954.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 444,954.5 мянган төгрөгийн зөрчилд 55.0 мянган төгрөгийн акт 1 тогтоож, 444,899.5 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 444,954.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 55.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 444,899.5 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд зарцуулсан шатахууны зардлыг ЗТХС-ын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтад заагдсан автомашины 100км-т зарцуулах жишиг нормоор дахин тооцоолоход 55.0 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтын хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлэв.



2. Тайлант оны эцэст 440,342.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллогыг хангалтгүй чанаргүй хийсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1 дэх “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.”, 12.2.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 12.2.2-т “эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед”, УСНББОУС 1-Санхүүгийн тайлангийн толилуулгад нийцэхгүй, оршин байх, эрх ба үүрэг, үнэлгээ, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант хугацаанд гарсан зардлаас 4,257.5 мянган төгрөгийн зардлыг и-баримт цахим системд бүртгүүлээгүй нь СС-ын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөх гэсэн тушаалыг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

4. Нэмэлт санхүүжилтийн дансны 300.0 мянган төгрөгийн зарцуулалтын анхан баримт бүрдүүлэлт хангалтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Төсвийн тухай хуулийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Хөрөнгийн тооллогыг чанартай бодитоор хийхгүй байгааг дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудалд авч үзлээ.



4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Дорнод аймгийн Матад сумын соёлын төв 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2021.02.15			ДОА-2021/44/СТА-ТШЗ

Шалгагдсан байгууллагын нэр:	Дорнод аймгийн Матад сумын Соёлын төв	Мянган төгрөг
------------------------------	--	---------------

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант жилийн эцэст хөрөнгийн тооллого хийгээгүй баримт байхгүй байна. Тооллогын баримт хангалтгүй, чанаргүй тооллого хийсэн. БМ-35,850 мянган төгрөг, ҮХ-404,492,0 мянган төгрөг	440,342.0	Албан шаардлага өгөх	СТ-ийн эрхлэгч Нягтлан бодогч	Д.Амарсанаа Т.Бадмаараг
2	Нийт 143 мэдээллийг хугацаанд нь оруулсан ба Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр 8 сард) 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	0.0	Албан шаардлага өгөх	СТ-ийн эрхлэгч Нягтлан бодогч	Д.Амарсанаа Т.Бадмаараг
3	Нэмэлт санхүүжилтийн дансанд 456000 төгрөг орж, 156000 төгрөгөөр урлагийн дээл худалдан авсан. 300000 төгрөгөөр соёлын цаг хөтөлбөрийн үйл ажиллагааны зардалд зарцуулсан анхан шатны баримт бүрдүүлэлт хангалтгүй.	300.0	Албан шаардлага өгөх	СТ-ийн эрхлэгч Нягтлан бодогч	Д.Амарсанаа Т.Бадмаараг
4	Харилцахаас 15,301.3 мянган төгрөгийн зардал төлөгдсөнөөс 4,257.5 мянган төгрөгийн баримт татварын цахим системд бүртгэлгүй байна. Матад шимт баялаг-2,800.0 мянган төгрөг, Мөнх оргилох эрдэм-143.0 мянган төгрөг, Улаан айраг - 1,314.5 мянган төгрөг тус тус шивэгдээгүй байна.	4,257.5	Албан шаардлага өгөх	СТ-ийн эрхлэгч Нягтлан бодогч	Д.Амарсанаа Т.Бадмаараг
5	Батлагдсан төсөвт 425,0 мянган төгрөг бөгөөд шатахуун зарцуулалтыг жишиг нормоор тооцоолоход 55.0 мянган төгрөгийн илүү зарцуулалттай байна.	55.0	Төлбөрийн акт тогтоох	СТ-ийн эрхлэгч Нягтлан бодогч	Д.Амарсанаа Т.Бадмаараг
ДҮН		444,954.5			